



**“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ТӨРИЙН ӨМЧИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

**Дотоод албан томилолтын хугацааг
сунгах тухай**

Сангийн сайдын 2018 оны “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 301 дүгээр тушаал, Компанийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, Хөдөлмөрийн дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.11, Албан томилолтын журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/13 дугаар тушаалаар дотоод албан томилолтоор орон нутагт ажиллаж буй Дэд дахирал Р.Ариунбат, Арилжааны мэргэжилтэн Х.Сайнбуян, Н.Бат-Эрдэнэ, Цахим хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн О.Цолмонбаатар, Ж.Батбаяр, Ложистикийн мэргэжилтэн Б.Лхагвадорж, Г.Батхишиг, Барааны шинжээч Т.Мөнхболор, Бүртгэлийн мэргэжилтэн И.Анхбат, Аж ахуйн ажилтан Д.Дугардорж нарын томилолтын хугацааг 2021 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс 03 дугаар сарын 25-ны өдрийг дуустал хугацаагаар сунгасугай.
2. Албан томилолтын хугацаа сунгасантай холбоотой гарах зардлын төсвийг хавсралтаар баталж, томилолтын зардлын төсөв болох 1,550,000 /Нэг сая таван зуун тавин мянга/ төгрөгийг Компанийн 2021 оны батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг Ерөнхий нягтлан бодогч /Ч.Аюурзана/-д зөвшөөрсүгэй.
3. Албан томилолтоор ажилласан талаарх тайланг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн дотор танилцуулахыг Дэд захирал /Р.Ариунбат/-д үүрэг болгосугай.
4. Тушаалыг холбогдох ажилтнуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын нэгж /Х.Энх-Амгалан/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Д.ДАНДИЙ-ЯДАМ



000000004